



**ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 07 сарын 22 өдөр

Дугаар A/037

Улаанбаатар хот

**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн
сургалтын хөтөлбөр, үнэлгээний тариф
шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.2, 12.2.11, 12.3, 51 дүгээр зүйлийн 51.5, 51.6 дахь хэсэг, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1455 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын дүрмийн 6.7.2, 6.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч байгууллага, аймаг, нийслэл, орон нутгийн удирдлага, албан хаагч, хөрөнгө оруулагч, хувийн хэвшил болон бусад сонирхогч этгээдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх ойлголтыг сурталчлан таниулах, мэдээлэх, хууль, журам, аргачлалын хэрэглээг нэг мөр ойлгуулах, шаардлагатай сургалт, семинар, арга зүйн дэмжлэгийг зохион байгуулах зорилгоор “Түншлэлийн төвөөс зохион байгуулах сургалтын хөтөлбөр, үнэлгээний тариф”-ыг хавсралтаар баталсугай.

2. Түншлэлийн төвөөс зохион байгуулах сургалтын төлбөрийг хавсралтаар баталсан тариф, захиалагч байгууллагатай байгуулсан гэрээ, баталгаажсан захиалга, сургалтын хөтөлбөр, зардлын тооцоо, нэхэмжлэх, гүйцэтгэлийн акт болон холбогдох санхүүгийн баримтад үндэслэн тооцож, захиалагч талаас нэхэмжлэн ажиллахыг Захиргаа, санхүүгийн газар /Д.Цоож/-т үүрэг болгосугай.

3. Улаанбаатар хотоос бусад байршилд сургалт зохион байгуулах, эсхүл захиалагчийн хүсэлтээр нэмэлт үйлчилгээ үзүүлэх тохиолдолд сургагч багш, мэргэжилтний томилолт, тээвэр, байр, хоол, сургалтын танхим, техник хэрэгсэл, хэвлэмэл материал, орчуулга болон бусад шууд зардлыг батлагдсан тариф дээр нэмж тооцох бөгөөд уг нэмэлт зардлын хэмжээг холбогдох баримт, зардлын тооцоонд үндэслэн захирлын шийдвэрээр баталгаажуулсугай.

4. Сургалтыг зохион байгуулахад ашиглах танилцуулга, гарын авлага, дасгал ажил, загвар маягт, тооцооллын файл, сургалтын бусад материалыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Засгийн газрын баталсан холбогдох журам, аргачлал, олон улсын сайн туршлагад нийцүүлэн нэгдсэн загвар, стандартын дагуу боловсруулж, шинэчлэн бэлтгэхийг Судалгаа, хамтын ажиллагааны газар /С.Ганзориг/-т үүрэг болгосугай.

5. Төрийн бодлогын хүрээнд, Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиглэл, хүсэлтээр, эсхүл олон нийтэд чиглэсэн танин мэдүүлэх шинжтэй сургалт, мэдээллийн арга хэмжээг үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй зохион байгуулах асуудлыг тухайн сургалтын зорилго, санхүүжилтийн эх үүсвэр, байгууллагын төсөв, төлөвлөгөөнд үндэслэн захирлын шийдвэрээр тухай бүр шийдвэрлэсүгэй.

6. Сургалтын үйлчилгээний орлогыг нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн тайлагнал, байгууллагын дотоод журамд нийцүүлэн бүртгэж, холбогдох дансанд төвлөрүүлэх, нэхэмжлэх, төлбөрийн баримт, гүйцэтгэлийн акт үйлдэх, тайлагнах ажиллагааг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн газар /Д.Цоож/-т даалгасугай.

7. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Түншлэлийн төвийн захирлын 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний тариф батлах тухай” А/034 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, сургалтын чанар, оролцогчдын үнэлгээ, орлого, зарлагын тайлан, үр дүнгийн мэдээллийг улирал тутам нэгтгэн танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн газар /Д.Цоож/ болон Судалгаа, хамтын ажиллагааны газар /С.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв
ТӨААТҮГ-ын захирлын 2026 оны 07
дугаар сарын 22-ны өдрийн 1/037 дугаар
тушаалын хавсралт



ТҮНШЛЭЛИЙН ТӨВӨӨС ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ТАРИФ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү хөтөлбөр, тариф нь Түншлэлийн төвөөс зохион байгуулах сургалт, семинар, танилцуулга, арга зүйн зөвлөгөөний үйлчилгээний агуулга, зорилтот бүлэг, нэгж үнэ, төлбөр тооцох нөхцөлийг тодорхойлно.

1.2. Дараах тариф нь Түншлэлийн төвөөс үзүүлэх сургалтын үндсэн тариф байх бөгөөд тарифын хэмжээг өөрчлөхгүйгээр тухайн сургалтын төлбөрийн эцсийн хэмжээг захирлын шийдвэрээр тухай бүр тогтооно.

1.3. Байгууллагын захиалгат сургалтын хувьд “өдрийн тариф”-ыг, нээлттэй бүртгэлтэй сургалтын хувьд “нэг хүний тариф”-ыг тус тус баримтална. Өдрийн тариф болон нэг хүний тарифыг давхардуулан тооцохгүй.

1.4. Төлбөрийн дүнд сургалтын үндсэн агуулга боловсруулах, сургагч багшийн бэлтгэл, сургалт явуулах, сургалтын үндсэн материал, ирц, үнэлгээний нэгтгэл, сургалтын тайлан багтана.

1.5. Танхим, хоол, кофе брейк, орон нутгийн томилолт, орчуулга, тусгай тоног төхөөрөмж, хэвлэмэл гарын авлагын нэмэлт зардлыг захиалагчийн хүсэлт, бодит зардлын баримтад үндэслэн тусад нь тооцно.

Хоёр. Сургалтын багц, тариф

№	Сургалтын гол сэдэв, товч агуулга	Хавсралт	Зорилтот бүлэг	Нэгж	Тоо, хэмжээ	Үнэлгээ, төг.
1.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай ойлголт, хууль, журмын талаарх сургалт	Хавсралт 1	Орон нутаг, хувийн хэвшил, салбар яамд	Өдөр Хүн	1 1	3,500,000 350,000
2.	Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээний сургалт	Хавсралт 2	Орон нутаг, хувийн хэвшил, салбар яамд	Өдөр Хүн	1 1	4,500,000 450,000
3.	Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний сургалт	Хавсралт 3	Орон нутаг, салбар яамд	Өдөр Хүн	3 1	8,500,000 850,000
	1-р хэсэг - ТХХТ -ийн төслийн бүрэн шинжилгээ					
	2-р хэсэг - Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ					
	3-р хэсэг - Түншлэлийн төслийн эрсдэлийн шинжилгээ					

4.	Түншлэлийн төслийг зарлах, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах сургалт	Хавсралт 4	Орон нутаг, хувийн хэвшил, салбар яамд	Өдөр Хүн	1 1	4,500,000 450,000
----	---	------------	--	-------------	--------	----------------------

Гурав. Төлбөрийн хэмжээг тогтоох нэмэлт зохицуулалт

3.1. Тухайн сургалтын төлбөрийн эцсийн хэмжээг сургалтын төрөл, агуулга, өдөр, цагийн хэмжээ, оролцогчийн тоо, сургалтын хэлбэр, зохион байгуулах байршил, нэмэлт материал, томилолт, тээвэр, байр, танхим, техник хэрэгслийн зардал болон захиалагч байгууллагатай байгуулсан гэрээ, ажлын даалгаварт үндэслэн захирлын шийдвэрээр тогтооно.

3.2. Захиалагч байгууллагаас сургалтын агуулга, хугацаа, байршил, оролцогчийн тоог нэмэгдүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд нэмэлт төлбөрийн хэмжээг зардлын тооцоонд үндэслэн захирлын шийдвэрээр баталгаажуулна.

3.3. Сургалтын төлбөр төлсөн нь Түншлэлийн төвөөс тухайн төсөл, санал, сонгон шалгаруулалт, гэрээний талаар эерэг дүгнэлт гаргах, дэмжлэг үзүүлэх, эсхүл аливаа шийдвэр баталгаажуулах үндэслэл болохгүй.

Дөрөв. Сургалтын агуулгын хүрээ

4.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай ойлголт, хууль, журмын талаарх сургалтын хөтөлбөр

№	Сургалтын сэдэв	Хуулийн заалт	Холбогдох журмын заалт
1	ТХХТ тухай ойлголт, түншлэлийн зарчим	1.1; 5.1.11; 4-р зүйл	
2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, ТХХТ тухай хууль болон дагалдах журмууд	1.1; 2.1; 4.1	
3	Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, ерөнхий бүтэц, гол нэр томьёо	1.1; 5.1	
4	Төрийн болон хувийн түншлэгчийн эрх, үүрэг, оролцоо	1.1	
5	Түншлэлийг хэрэгжүүлэх салбар, түншлэлийн төрөл, хэлбэр	2.1	
6	Түншлэлийн төслийн үе шат, ерөнхий зураглал, цаг хугацаа	17-р зүйл	
7	Түншлэлийн төсөлд тавих нийтлэг болон тусгай шаардлага	18-р зүйл	
8	Түншлэлийн төслийн төлөвлөлт, урьдчилсан үнэлгээний ерөнхий ойлголт	10.1; 19-р зүйл	
9	Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний ерөнхий ойлголт	20-р зүйл	
10	ТХХТ төслүүд дээр төрөөс үзүүлэх дэмжлэг	7.1.3	
11	ТХХТ-ийн төслүүдийг хэрэгжүүлсэн олон улсын туршлага	25.1.3	

4.2. Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээний сургалтын хөтөлбөр

№	Сургалтын сэдэв	Хуулийн заалт	Холбогдох журмын заалт
1	Урьдчилсан үнэлгээний зорилго, агуулга	19-р зүйл	ЗГ-404-Х1 - 1.1
2	Урьдчилсан үнэлгээний үе шат, ерөнхий зураглал, цаг хугацаа	17-р зүйл; 19.3; 22.2; 23.1	ЗГ-404-Х1 - 4.1
3	Төслийн үндсэн мэдээлэл, танилцуулга		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 1
4	Төслийн нийгмийн ач холбогдлын мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 2
5	Төслийн эдийн засгийн бусад үр ашгийн талаарх мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 3
6	Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 4
7	Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж буй талаарх мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 5
8	Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 6
9	Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 7
10	Ажлын байрны мэдээлэл		ЗГ-404-Х1 Хавсралт 1, Маягт 8
11	Олон улсын туршлага		

4.3. Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний сургалтын хөтөлбөр

№	Сургалтын сэдэв	Хуулийн заалт	Холбогдох журмын заалт
1.1	ТХХТ-ийн төслийн бүрэн шинжилгээний зорилго	5.1.30; 20.4	ЗГ-404-Х1
1.2	Бүрэн шинжилгээний үе шат, ерөнхий зураглал	17-р зүйл; 20-р зүйл	ЗГ-404-Х1
1.3	Бүрэн шинжилгээний төслийн баг байгуулах, чиг үүрэг, эх төсөл боловсруулах	20-р зүйл; 11.2.4; 12.2.3	ЗГ-404-Х1
1.4	Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ, мөнгөний үнэ цэнийн шинжилгээ	20.4	ЗГ-404-Х1 Хавсралт 2
1.5	Урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах	20.4	ЗГ-404-Х1
1.6	Түншлэлийн гэрээний төрөл, загвар, гол нөхцөл, шаардлагын үнэлгээ	20.4	ЗГ-404-Х1
1.7	Хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ	20.4	ЗГ-404-Х1
1.8	Түншлэлийн төслийн эрсдэлийн шинжилгээний ерөнхий ойлголт	20.4	ЗГ-404-Х1
1.9	Түншлэлийн төрөл, гэрээний хэлбэр, хэрэгжих хугацаанд дүгнэлт гаргах	20.4	ЗГ-404-Х1
1.10	Төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөлд дүгнэлт гаргах	20.4	ЗГ-404-Х1
1.11	Төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийн дүгнэлт	20.4	ЗГ-404-Х1
2.1	Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох	20.4	ЗГ-404-Х1 Хавсралт 2
2.2	Үйл ажиллагааны орлого, зардлын тооцоо хийх	20.4	ЗГ-404-Х1 Хавсралт 2

№	Сургалтын сэдэв	Хуулийн заалт	Холбогдох журмын заалт
2.3	Ирээдүйд гарах зардлын тооцоог таамаглах	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.4	Цэвэр ашиг, мөнгөн урсгалын тооцоо хийх	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.5	NPV, IRR тооцоолол хийх	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.6	Төсвөөс үзүүлэх дэмжлэгийг тооцоолох	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.7	Мөнгөний үнэ цэнийн урьдчилсан болон дэлгэрэнгүй шинжилгээ	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.8	Мөнгөний үнэ цэнийн чанарын шинжилгээ	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
2.9	PPP-PSC харьцуулалт	20.4	ЗГ-404-X1 Хавсралт 2
3.1	Эрсдэлийн шинжилгээний гол зорилго, хамрах хүрээ	5.1.29; 20.4.5	ЗГ-404-X4 - 1.4
3.2	Төслийн эрсдэл, бууруулах арга хэмжээг тодорхойлсон шинжилгээ	5.1.29	ЗГ-404-X4
3.3	Эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх	30.1	ЗГ-404-X4
3.4	Эрсдэлийн удирдлагын нэгдсэн матрицыг боловсруулах		ЗГ-404-X4 - 5.5
3.5	Төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийн дүгнэлт, PFRAM	9.1; 9.2	ЗГ-404-X4
3.6	Эрсдэлийг бууруулах хүрээнд Засгийн газрын баталгаа гаргах	31-р зүйл; 5.1.31; 9.1.7; 21.5.3	ЗГ-404-X4

4.4. Түншлэлийн төслийг зарлах, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах сургалтын хөтөлбөр

№	Сургалтын сэдэв	Хуулийн заалт	Холбогдох журмын заалт
1	Сонгон шалгаруулалтын зорилго	4.1.5	
2	Төслийг зарлах, сонгон шалгаруулах үе шат, ерөнхий зураглал	4-р бүлэг; 17-р зүйл; 21.9	
3	Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг, зохион байгуулалт, ажиллах журам	4-р бүлэг	
4	Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох, гэрээний хэлэлцээр хийх	4-р бүлэг; 18.2.12; 25.6.9	
5	Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт	4-р бүлэг	
6	Сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх заавар	4-р бүлэг	
7	Техникийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	4-р бүлэг	
8	Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	4-р бүлэг	
9	Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг	4-р бүлэг	
10	Түншлэлийн төслийг сонгон шалгаруулах олон улсын туршлага		